



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4,281,748.00 (дөрвөн сая хоёр зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин найман) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.“Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Л.Гантөмөрт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


2.1.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2.Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001893

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн  
 278 дугаар тогтоолын хавсралт



“Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори”  
 төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,  
 данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арал, хөдөлгүүр	Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			/төгрөг/		
1	Соната -2, УБР-55-15, суудлын, арал:008676, хөдөлгүүр:01684	1993/2001	4,281,748.00	4,281,748.00	-
Нийт дүн			<b>4,281,748.00</b>	<b>4,281,748.00</b>	-
			<b>(дөрвөн сая хоёр зуун наян нэгэн мянга долоон зуун дөчин найман)</b>		